

Маргааны товч

Нэхэмжлэгч “Талын гал” ХК-ийн “Ашигт малтмал, газрын тосны газрын Хэрэг эрхлэх газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2008 оны 1396 дугаар шийдвэрийн “Энгүй тал” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг анхан шатны шүүх “маргаан бүхий захиргааны актыг 6 дахин шинэ акт гаргахыг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж, тогтоосон хугацаанд хариуцагч шинэ акт гаргаагүй бол маргаан бүхий захиргааны актын “Энгүй тал” ХХК-д холбогдох хэсэг хүчингүй болгохыг дурдаж” шийдвэрлэснийг Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хэвээр үлдээжээ.

Гуравдагч этгээд “Энгүй тал” ХХК-аас “анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэж байх үед хариуцагч байгууллага “Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын лиценз бүхий талбайд 2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайлан”-г өгөлгүй өөр хайгуулын ажлын тайланг шүүхэд гарган өгсөн” үндэслэлээр хүсэлт гаргасан.